



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16,
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020.07.21 № 02

Асуулт тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 284 дүгээр тогтоолоор Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн авто замын хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг 4 эгнээ бүхий хатуу хучилттай авто зам болгон өргөтгөн, шинэчлэх шийдвэрийг гаргасан.

Тус замыг 2020 оны 06 сарын 20-ны өдрийн дотор бүрэн ашиглалтад хүлээлгэж өгөхөөр төлөвлөсөн хэдий ч өнөөдрийг хүртэл уг зам нь хугацаандаа ашиглалтад ороогүй. Түр зам нь эвдрэл ихтэй, тэмдэг тэмдэглэгээ байхгүй зэргээс болж аваар ослоор хүний амь нас эрсдэх, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирох ноцтой зөрчил удаа дараа гарч байгаа талаар иргэд, байгууллагаас гомдол, саналаа бидэнд илэрхийлж, уг замын ажлыг богино хугацаанд дуусгахыг шаардаж байна.


Иймд Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын явцын талаар;
2. Гүйцэтгэгч байгууллагуудын техник, санхүү, хүн хүчний нөөц тус замыг барьж чадах эсэх, танай яамны зүгээс хяналт шалгалтын ажлыг хэрхэн хийж, ямар дүгнэлт хийж байгаа талаар;
3. Тухайн замыг яаралтай ашиглалтад оруулахад тулгарч буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дугаар зүйлийн 39.8 дахь хэсэгт заасны дагуу ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Г.ДАМДИННЯМ

0000000027